

ИНЕГ-ЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2020, 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.02.25

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “ИНЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 01/22 тоот удирдамжийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийг дуустал хугацаанд ИНЕГ-ын СХОГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, ахлах мэргэжилтэн М.Мөнгөншагай, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут, Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд СХОГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацааны касс, харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, бараа материалын бүртгэл зэргийг нягталж шалгахгаас гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа. Дотоод аудитаар дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

НБББББ-ийг зөрчиж хүчингүй болсон анхан шатны бүртгэлийн маягтыг үйл ажиллагаандаа ашигласан.

СХОГ-ын 2020, 2021 онуудын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, архивын баримтыг үзэхэд хадгалах хугацааны хувьд ялгаатай бүхий л дараа тайлангийн тооцоо, тайлан, баримтыг тусад нь архивын нэгж болгоогүй, харилцах болон кассын баримттай хамт архивласан нь ИНЕГ-ын НББбодлогын баримт бичиг, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Үндэсний архивын газрын даргын 2007 онд баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг тус тус зөрчсөн.

ИНЕГ-ын 2021 оны гадны байгууллагын өглөг дансны бүртгэлийг шалгахад ИКАО-ын гишүүнчлэлийн хураамжид төлсөн 142.3 сая төгрөгийн гүйлгээг мөнгөн сууриар илэрхийлснээр улирал, хагас жилээр тайлангийн зардал илүү бүртгэсэн байна.

ИНЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Гадаадад сургалтад хамруулах тухай А/25 дугаар тушаалын дагуу гарсан зардлыг НБББББ-т заасан бүртгэлийн бодлогыг зөрчиж хуримтлагдсан ашиг дансруу бүртгэсэн. Мөн 2021 оны тайлант хугацааны Хуримтлагдсан ашиг дансны бүртгэлийг шалгахад 22,840,930 төгрөгийн авлагыг ИНЕГ-ын НБББББ-ийн 4.2.2.-т заасан ...Найдваргүй авлагыг данснаас хасах үед: (Эрх бүхий байгууллагын шийдвэр, Шүүхийн шийдвэр, холбоотой баримт бичгийг үндэслэн удирдлагын шийдвэрээр)... шийдвэргүйгээр бүртгэсэн.

ИНЕГ-ын НБББББ-ийн 4.2.2 Авлага ба урьдчилгаа тооцооны бүртгэлийн бодлого, Авлагын баталгаажуулалт, 4.6.2 Өр төлбөрийн бүртгэлийн бодлого, Өр төлбөрийн баталгаажуулалтыг харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийг хагас жил, жилийн эцэст тулган тохируулж тооцоо нийлсэн актыг үйлдэнэ... гэж заасныг зөрчиж гадаадын авиакомпаниудаас авах авлага, өглөгийг жилийн эцэст тооцоо нийлсэн акт үйлдэж байна.

ИНЕГ-ын НБББББ-ийн 4.12.3-т ...ИНЕГ-ын систем хоорондын тооцоо, Систем хоорондын тооцоог нийлж тохируулах, хаах хэсэгт систем хоорондын тооцоог сар бүрийн эцэст нийлж тохируулна... гэж заасны дагуу тооцоо нийлж, тохируулж, баталгаажуулсан баримт үйлдээгүй байна.

ИНЕГ-ын (Агентлаг, Үйлдвэрлэл) 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад оруулсан мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байдал 96.9 хувьтай, мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал 100 хувьтай байна.

Шилэн дансны цахим хуудсанд агентлаг хэсэгт 149 мэдээлэл байршуулахаас 5 мэдээллийн хугацааг хоцроосон, ИНЕГ-ын үйлдвэрлэл үйлчилгээ хэсэгт 146 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийн хугацааг хоцроосон. Энэ нь 2021 оны төсөв төлөвлөгөө батлагдаагүй болон нягтлан бодогч нь хугацаандаа оруулсан мэдээллийг дахин орж хадгалснаас хугацаа хоцроосон байна.

ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд ҮАГ-аас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ИНЕГ-т нийт 1 төлбөрийн акт, 6 албан шаардлага, зөрчил дутагдлыг засах залруулахаар 2 зөвлөмжийг өгсөн. Тус аудитын актын биелэлт 100%-тай, албан шаардлагын биелэлт 60 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 65 хувьтай хангалтгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус газарт 16 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА